

“Ремикон” ХК
Хараат бус Аудиторын тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Ремикон ХК

Ремикон ХК.....	0
1. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	1
2. АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
3. АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
4. АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
5. АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
6. АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	9
7.1 Байгууллагын талаарх мэдээлэл.....	9
7.2 Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн болон эрх зүйн орчин.....	9
7.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	10
7.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10
7.4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	11
7.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	11
7.5 Авлага	11
7.5.1 Дансны авлага	12
7.5.2 Татвар НДШ-ийн авлага	12
7.6 Урьдчилж төлсөн тооцоо/зардал	13
7.7 Бараа материал	13
7.8 Үндсэн хөрөнгө	14
7.9 Биет бус хөрөнгө.....	17
7.10 Хайгуул үнэлгээний хөрөнгө	17
7.11 Өр төлбөр.....	17
7.11.1 Дансны өглөг	18
7.12 Эздийн өмч	19
7.13 Дахин үнэлгээний нэмэгдэл	20
7.14 Хуримтлагдсан үр дүн	20
7.15 Орлого, зардал	21
7.15.1 Борлуулалтын орлого.....	21
7.15.2 Бусад орлого.....	21
7.15.3 Борлуулалтын өртөг	22
7.15.4 Борлуулалт маркетинг болон ерөнхий удирдлагын зардал	22
7.15.5 Бусад зардал	22
7.15.6 Орлогын татварын зардал.....	22
7.16 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага.	23



“Ремикон” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдэд

“SHONKHOR UNELGEE. AUDIT” LLC

MEMBER OF RUSSELL
BEDFORD INTERNATIONAL

2025.04.29 № 25/00

№

АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Ремикон” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Ремикон” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланда хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай залт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчмитай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариусан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланда үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

- Хэрэглэсэн нягтлан бodoх бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бodoх бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бodoх бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болжог. Аудиторын тайлан гарах өдөр хүргэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)



АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
 2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант ўс

"Ремикон" ХК

(төгрөгөөр)

Балансын зүйл	2024.12.31	2023.12.31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Менгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,450,676.0	73,849,431.6
Дансны авлага	21,331,554,256.0	18,702,687,807.3
Татвар, НДШ – ийн авлага	1,838,928,518.2	651,808,846.3
Бараа материал	6,498,580,726.4	2,967,035,264.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,300,149,194.3	2,785,601,125.4
Эргэлтийн хөрөнгийн дүн	32,995,663,370.9	25,180,982,475.0
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,360,147,586.6	4,881,770,404.4
Биет бус хөрөнгө	1,573,132,712.8	1,573,132,712.8
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	394,946,125.1	326,081,549.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,328,226,424.5	6,780,984,666.8
Нийт хөрөнгийн дүн	39,323,889,795.4	31,961,967,141.8
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	3,829,435,032.2	4,408,100,214.5
Татварын өр	7,602,845,023.8	6,107,030,629.2
НДШ - ийн өглөг	28,048,049.6	276,371,093.3
Урьдчилж орсон орлого	471,150,000.0	157,892,000.0
Бусад богино хугацаат өр төлбөр	124,482,899.1	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,055,961,004.8	10,949,393,936.9
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	2,300,000,000.0	1,595,760,000.0
Бусад урт хугацаат өр төлбөр	4,166,447,971.5	3,976,293,899.3
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,466,447,971.5	5,572,053,899.3
Өр төлбөрийн нийт дүн	18,522,408,976.3	16,521,447,836.2
Эздийн өмч		
Омч		
Хувьцаат	7,867,946,406.0	7,867,946,406.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,559,755,876.9	2,559,755,876.9
Хуримтлагдсан ашиг	10,373,778,536.2	5,012,817,022.7
Эздийн өмчийн дүн	20,801,480,819.1	15,440,519,305.6
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	39,323,889,795.4	31,961,967,141.8



INTERNATIONAL

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант ѿ

"Ремикон" ХХК

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	36,231,552,591.6	30,745,392,838.1
Борлуулалтын өртөг	24,227,361,838.4	22,066,119,204.8
Нийт ашиг (алдагдал)	12,004,190,753.2	8,679,273,633.4
Хүүний орлого		944,351.7
Бусад орлого	28,833,865.4	37,336,480.1
Борлуулалт, маркетингийн зардал	1,961,913,718.3	1,274,255,476.1
Ерөнхий ба удирдлагын зардал	3,304,102,261.3	2,110,841,455.2
Санхүүгийн зардал	729,070,502.9	751,571,080.1
Бусад зардал	40,458,482.9	120,646,785.2
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(21,127.4)	(261,311.7)
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	5,997,458,525.7	4,459,034,005.3
Орлогын татварын зардал	638,242,390.3	504,890,396.0
Татварын дараах ашиг (алдагдал)	5,360,961,513.5	3,961,032,855.1
Зөгсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант ѿийн цэвэр ашиг (алдагдал)	5,360,961,513.5	3,961,032,855.1
Бусад дэлгэрэнгүй орлого		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	5,360,961,513.5	3,961,032,855.1



АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дууставар болсон тайлант үс

"Ремикон" ХК

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хурамтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	7,867,946,406.0	2,559,755,876.9	1,515,033,423.9	11,942,735,706.8
Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,497,783,598.8	3,497,783,598.8
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	7,867,946,406.0	2,559,755,876.9	5,012,817,022.7	15,440,519,305.6
Нийтлан болдох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нелөө, алдааны замрзуулга	7,867,946,406.0	2,559,755,876.9	5,012,817,022.7	15,440,519,305.6
Зарцуулсан үлдэгдэл	-	-	5,360,961,513.5	5,360,961,513.5
Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	7,867,946,406.0	2,559,755,876.9	10,373,778,536.2	20,801,480,819.1



АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант ѿ

"Ремикон" ХК

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	19,230,926,374.4	15,745,447,918.5
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,814,079,052.1	15,368,958,114.6
Бусад мөнгөн орлого	416,847,322.3	376,489,803.8
Мөнгөн зарлагын дүн	19,457,697,118.5	15,530,894,793.0
Ажиллагчдад төлсөн	1,244,118,155.9	949,782,142.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	666,334,197.0	285,532,675.0
Бараа материал худалдан авахад төлсөн	12,834,963,732.3	11,514,353,317.6
Ашиглалтын зардалд төлсөн	13,326,471.3	12,816,235.4
Түвш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	56,477,722.7	21,630,139.6
Хүүний төлбөрт төлсөн	-	35,925,886.8
Татварын байгууллагад төлсөн	1,826,937,817.1	586,962,079.9
Даатгалын төлбөрт төлсөн	7,377,502.7	1,499,984.0
Бусад мөнгөн зарлага	2,808,161,519.5	2,122,392,332.7
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(226,770,744.1)	214,553,125.5
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,801,979.7	939,104.8
Хүлээн авсан хүүний орлого	1,801,979.7	939,104.8
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,801,979.7	939,104.8
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,753,009,252.3	800,779,688.3
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,752,992,210.6	800,000,000.0
Төрөл бүрийн хандив	17,041.6	-
Бусад	-	779,688.3
Мөнгөн зарлагын дүн	2,575,401,074.4	1,094,357,635.1
Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,575,401,074.4	1,094,357,635.1
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	177,608,177.9	(293,577,946.7)
Валютын ханшийн зөрүү	(38,169.1)	(1,041,000.0)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,398,755.6)	(79,126,716.4)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,849,431.6	152,976,148.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,450,676.0	73,849,431.6



7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

7.1 Байгууллагын талаарх мэдээлэл

“Ремикон” ХК нь 2008 оны 1 дугээр сарын 11-ний өдөр, улсын бүртгэлийн 9010001071, регистрийн 5191823 дугаартайгаар Улсын бүртгэлд бүртгэгдсэн. Нээлттэй буюу хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг ба хувьцаа нь MSE В индекс-ийн багцад багтдаг.

Үйл ажиллагааны төрлүүд:

- Барилгын материалын худалдаа
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Автомашин, механизмын худалдаа
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн хийгдэх бөөний худалдаа
- Автомашины ачаа тээвэрлэлт

Тусгай зөвшөөрлүүд

- Барилга хот байгуулалтын яамны MY 18-097/21 дугаартай “Бетон зуурмагийн үйлдвэр” ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай.
- Барилга архитектур корпораци бүтээгдэхүүн баталгаажуулалтын алба 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 24/21 000391 дугаартай, Тохирлын гэрчилгээ
- Стандарт хэмжил зүйн газар “Ремикон ХК-ийн барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори” Итгэмжлэлийн гэрчилгээ Дугаар TL 138 2 жилийн хугацаатай, Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, сонсголон 181, Ремикон үйлдвэрийн байр, 55 тоот.

Дүрмийн сангийн хэмжээ: 7,867,946,406 төгрөг

Гүйцэтгэх захирал: Э.Мөнхсайхан

Харилцах утас: 70123333

Нягтлан бодогч: Э.Эрдэнэцэцэг

Харилцах утас: 88880042

7.2 Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн болон эрх зүйн орчин

Монгол улсад өнөөдрийн байдлаар компанийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой дараах хуулиуд үйлчилж байна.

- Иргэний хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Архивын тухай хууль
- Барилгын салбарын холбогдох бусад хууль тогтоомж заавар журам

7.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Тайлан бэлтгэх үндэслэл.

“Ремикон” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-оос

баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоомжууд, Сангийн Яам болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар журам, аргачлалын дагуу бэлтгэгдсэн.

Бодит үнэ цэнэ нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогч талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө худалдах, эсхүл хөрөнгө солилцох, өр төлбөр барагдуулахад төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой үнийн талаарх хангалттай их хэмжээгээр гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг байнга авч болох газрыг хэлнэ.

Анхны өртөг гэдэг нь худалдан авалтын өдөр төлөгдсөн мөнгөн хөрөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн дүн, эсхүл хөрөнгө худалдаж авахад зориулагдсан бусад нөөцийн бодит үнэ бөгөөд үүнд хэлцэл болон ажил гүйлгээний зардлууд орно.

Аккруэл суурь нь: ажил гүйлгээ үйл явдлыг гарсан буюу тохиолдсон үед нь (мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан эсвэл төлсөнөөс үл хамааран) хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

Тасралтгүй байх зарчим нь: байгууллага одоо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд урьдчилан харж болох ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна гэсэн төсөөллийг хэлнэ.

7.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ. Харин гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрөхдөө нэрлэсэн үнээр нь бүртгэхээс гадна НББОУС 21-д заасны дагуу тухайн ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон албан ханшаар төгрөгт хөрвүүлж валют, төгрөгөөр давхар бүртгэнэ.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд З сараас дээшгүй хугацаатай, тодорхой мөнгөн дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай, харьцангуй эрсдэл бага байдаг богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна.

- Бэлэн мөнгө (касс):
- Банкин дахь бэлэн мөнгө (харилцах):
- Хугацаагүй мөнгөн хадгаламж:
- Хугацаатай хадгаламж (З сараас дээшгүй хугацаатай)
- Замд яваа мөнгө:
- Банкны карт дахь мөнгө:
- Банкны хязгаарлагдсан дансан дахь (банктай байгуулсан гэрээний дагуу авсан зээлийн өрийн тодорхой хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгийг тусгаарлах)
- Барьцаалагдсан мөнгө: (Гэрээ хэлцлийн нөхцөл болон хууль хяналтын байгууллагаас бодитой шалтгаанаар, тодорхой хугацаанд захиран зарцуулах гүйлгээний эрхийг нь хязгаарласан мөнгө)

7.4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Касс дахь бэлэн мөнгө /төгрөг/	2,885,202.7	9,608,454.2
Касс дахь бэлэн мөнгө /доллар/	316,161.6	316,392.1
Чингис хаан банк /төгрөг/	500.0	500.0
Чингис хаан банк /доллар/	27,007.9	27,664.0
Худалдаа хөгжлийн банк /төгрөг/	19,000.0	2,551,966.0
Худалдаа хөгжлийн банк /доллар/	13,000.1	36,380.1
Хаанбанк /төгрөг/	2,838,500.0	29,194,369.3
Хасбанк /төгрөг/	8,153,644.8	-
Үндэсний хөрөнгө оруулалтын банк /төгрөг/	12,000.0	-
Үндэсний хөрөнгө оруулалтын банк /доллар/	60,565.3	797,587.7
Голомт банк /төгрөг/	60,531.5	97,377.3
Голомт банк /доллар/	1,843,025.0	14,554,029.2
Тээвэр хөгжлийн банк /төгрөг/	4,264,673.0	4,883,362.9
Тээвэр хөгжлийн банк /доллар/	5,147,359.6	5,147,359.6
Дүн	26,450,676.0	73,849,431.6

7.5 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Үнэ цэнийг өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг, 3 сар ба түүнээс богино хугацаатай хөрөнгө оруулалтыг хэлнэ.

7.6 Авлага

Авлага гэдэг нь компанийн хэвийн үйл ажиллагааны үр дүнд үйлчлүүлэгчид болон худалдан авагчдад зээлээр бараа бүтээгдэхүүн борлуулах, ажил үйлчилгээг гүйцэтгэх явцад ууссан хөрөнгийг хэлнэ.

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Авлагын цэвэр дун нь дансны авлагын нийт дүнгээс найдваргүй авлагын хасагдуулгыг хассантай тэнцүү байна. Найдваргүй авлагын нөөцийг тооцоходоо авлагын насхилтанд үндэслэн хувийн жингийн аргыг хэрэглэнэ. НББББ-т тусгаснаар найдваргүй авлагын нөөц санг дараах байдлаар байгуулж ажиллана.

Авлагыг цаг хугацаанаас хамааруулан дараах байдлаар ангилна. Үүнд:

- Эргэлтийн буюу богино хугацаат авлага: Богино хугацаатай буюу нэг жилийн дотор цуглуулагдах бараа, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
- Эргэлтийн бус буюу урт хугацаат авлага: Ихэвчлэн хөрөнгө оруулалтын шинж чанартай борлуулалтын бус урт хугацааны үйл ажиллагаатай холбогдон бий болж байгаа нэг жилээс дээш хугацаанд цуглуулагдах авлагыг хэлнэ.

Авлагыг төлөгдөх байдлаар нь дараах байдлаар ангилна.

- Хэвийн
- Хэвийн бус
- Хугацаа хэтэрсэн авлага гэж ангилна.

Найдваргүй авлагын нөөцийг тооцохдоо авлагын насжилтанд үндэслэн хувийн жингийн аргыг хэрэглэнэ. НББББ-т тусгаснаар найдваргүй авлагын нөөц санг дараах байдлаар байгуулж ажиллахыг шаарддаг.

ДД	Авлагын ангиалал	Буцаан толох хугацаа хэтэрсэн хоног
1	Хэвийн	Төлөгдөх хугацаандaa байгаа болон 15-30 хоног хэтэрсэн
2	Анхаарал хандуудах	90 хуртэлх хоног
3	Хэвийн бус	91-180 хоног
4	Эргэлзээтэй	181-360 хоног
5	Муу	361 хонгоос дээш хонгоос хугацаа хэтэрсэн болон харилцагч нас барсан

7.6.1 Дансны авлага

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Түрээсийн авлага	145,602,803.5	-
Холбооны төлбөрийн авлага	-	8,436,267.8
Байгууллагаас авах авлага	1,311,845,957.7	2,018,558,123.2
Холбоотой талын авлага	173,653,246.4	181,006,646.4
Бусад авлага - хуулийн хэлтэст	75,175,998.0	77,023,023.0
Бусад авлага - хуулийн зөвлөх	1,876,842,356.0	1,823,342,278.0
Хувь хүмүүсээс авах авлага	16,333,545,435.3	14,141,844,983.3
Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага	393,086,932.0	169,298,069.0
Найдваргүй авлагын хасагдуулга	(1,265,780,803.4)	(1,265,780,803.4)
Ажилчдаас авах авлага	143,300,168.6	114,239,220.1
Бусад	2,2139,282,162.0	1,434,720,000.0
Дүн	21,331,554,256.0	18,702,687,807.3

7.6.2 Татвар НДШ-ийн авлага

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
НӨАТ-ийн авлага	1,825,556,445.1	638,448,054.8
ААНОАТ-ын авлага	11,281.7	-
ҮХХөАТ-ын авлага	13,360,791.5	13,360,791.5
Дүн	1,838,928,518.2	651,808,846.3

7.7 Урьдчилж төлсөн тооцоо/зардал

Урьдчилж төлсөн тооцоо нь тайлант хугацаанд мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант хугацаанд зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ. Урьдчилгаа буюу урьдчилж төлсөн тооцоо нь мөнгө, бараа материал, үйлчилгээгээр хаагдах тооцоо юм.

Урьдчилж төлсөн зардал нь мөнгө, бараа, үйлчилгээ буцаан авахгүй харин зардал болж, орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх зарлагыг илэрхийлнэ.

Урьдчилгаа тооцоог шинж чанараас нь хамааруулан дараах гурван хэсэгт ангилж үзнэ. Урьдчилж төлсөн тооцоо: Худалдан авах бараа, үйлчилгээний үнийг урьдчилан төлсөн тооцоо болон мөнгөөр төлөөд буцаан мөнгөн хэлбэрээр барагдуулах зориулалтаар үүссэн тооцоог хамааруулна. Тухайлбал: Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа, татварын тооцоо гэх мэт.

Урьдчилж төлсөн зардал: Нэг буюу хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг бөөнд нь урьдчилан төлсөнтэй холбоотой үүссэн тооцоог хамааруулах ба эдгээр тооцоо нь системтэйгээр зардал хэлбэрээр хүлээн зөвшөөрөгднө. Жишээ нь: урьдчилан төлсөн даатгалын зардал, үйл ажиллагааны түрээс гэх мэт.

Дотоод тооцоо: Ажилтан албан хаагчдад дараа тооцоо хийхээр олгосон урьдчилгааны тооцоог бүртгэнэ.

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Урьдчилж төлсөн тооцоо /ДТА/	3,125,234.0	42,737,822.2
Урьдчилж төлсөн тооцоо /шатахууны карт/	-	1,317,000.0
Урьдчилж төлсөн тооцоо /гэрээ/	4,780,000.0	33,933,718.0
Урьдчилж төлсөн тооцоо /ТЭМ/	3,272,690,974.8	2,611,744,200.8
Урьдчилж төлсөн тооцоо /ХҮХ/	-	51,920,758.0
Урьдчилж төлсөн тооцоо /барилга/	-	24,394,641.0
Урьдчилж төлсөн тооцоо /үнсний селоз/	19,552,985.5	19,552,985.5
Дүн	3,300,149,194.3	2,785,601,125.4

7.8 Бараа материал

Нэг жилээс дотогш хугацаанд ашиглах зарим төрлийн хөрөнгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч, бараа материалын дансны булэгт хангамжийн материал гэсэн хэсэгт бүртгэж болно.

Компани нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгоходоо Эхэлж Авсныг Эхэлж Зарлагадах аргаар зарлагадах бөгөөд бараа материалын байнгын систем ашиглана. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ хүртэл бууруулсан аливаа дүн болон бараа материалын бүх гарзыг уг бууруулах бичилт хийгдсэн эсвэл гарз гарсан тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүн юм. Бараа материалыг өртгөөр нь бүртгэж, өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлж балансад тусгана.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын өртөг мөн одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно.

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Түүхий эд материал	761,109,377.3	276,541,023.7
Бэлэн бүтээгдэхүүн	5,342,912,763.7	2,212,165,717.3
Сэлбэг хэрэгсэл	73,098,769.9	55,939,760.1
Сэлбэг хэрэгсэл /багаж хэрэгсэл/	13,208,234.8	12,584,628.7
Сэлбэг хэрэгсэл /помп/	96,210,535.0	100,646,262.4

Сэлбэг хэрэгсэл /авто/	128,061,383.2	125,734,368.4
Сэлбэг хэрэгсэл /хангамж/	3,854,545.5	127,985,417.1
Хангамжийн материал	54,815,763.3	26,772,396.5
Шатахуун, шатах тослох материал	25,309,353.9	28,665,690.2
Дүн	6,498,580,726.4	2,967,035,264.5

7.9 Үндсэн хөрөнгө

Үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа, Нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах биет зүйлийг үндсэн хөрөнгө гэнэ.

Үндсэн хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгө байгууллагад үр өгөөжөө өгөх тооцоолсон хугацааг үндэслэн ашиглалтын хугацааг байгууллага өөрөө тодорхойлдог. Хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлоходо байгууллагын түүхэн туршилага, хөрөнгөнд үнэлгээчээс тогтоосон хугацаа, инженерийн үнэлгээ тооцоог удирдамж болгодог.

Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Өртөг гэдэг нь хөрөнгө худалдан авах эсвэл барьж байгуулах өдрийн бодит үнэ цэнэ эсвэл төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн эсвэл СТОУС-д заасан хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөд хувиарласан боломжит бусад дүн юм.

Үзүүлэлт

Ашиглалтын хугацаа /жилээр/

Барилга	25 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь техникийн ашиглалтын нөхцөл болон хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст тухайн хөрөнгө хуучирсан болон ашиглах хугацаа дууссан гэсэн таамаглалд үндэслэн компани нь уг хөрөнгийг борлуулах өдрийн байдлаар хүлээгдэж буй боломжит үнээс борлуулалтын зардлыг хасаж тооцсон дүнг хэлнэ.

Үлдэгдэл өртөг гэдэг нь үндсэн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны туршид хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын гарзыг хассан өртөг.

Дахин үнэлсэн үнэ гэдэг нь хөрөнгийн анхны өртөг эсвэл үлдэгдэл өртгийг шинэчлэн тогтоосон дүн.

Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлэх шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Санхүүгийн түрээс байдлаар түрээслэгчийн эзэмшиж буй хөрөнгийн өртгийг СТОУС 16 “Түрээс”-д зааснаар түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн аль бага дүн дээр түрээслэгчийн төлсөн анхдагч шууд зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Элэгдэл. Газраас бусад үндсэн хөрөнгүүдийг элэгдүүлдэг ба элэгдлийг тооцохдоо ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг холбогдох татварын хууль болон доорх хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө үнэ цэнээ алдаж байвал үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг НББОУС-36 “Үнэ цэнийн бууралт”-ын дагуу бүртгэнэ. Хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их болсон бол үнэ цэнэ буурсан гэж үзнэ. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль их нь байна.

Дансны үнэ >Нөхөгдөх дүн тохиолдолд үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын хэмжилтээр үнэ цэнэ буурсан бол уг бууралтыг тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан бөгөөд цаашид эдийн засгийн үр өгөөж өгөхгүй болсон тохиолдолд тооллогын комисс, бусад ажлын хэсгийн акт, дүгнэлтийг үндэслэн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу хөрөнгийг данснаас хасах ажил гүйлгээг бүртгэнэ.

Хөрөнгийн нэр	Газар	Барилга байгууламж	Тавилга, эд хогшил	Машин, тоног төхөөрөмж	Бусад үндсэн хөрөнгө	Бүгд
2023 оны 12-р сарын 31	475,200,000.2	5,225,561,435.9	112,354,369.0	9,171,786,068.7	7,726,909.1	14,992,628,782.8
Нэмэгдсэн дүн	-	30,250,000.0	12,596,272.7	184,261,004.5	17,957,154.5	245,064,431.8
Худалдан авсан	-	30,250,000.0	12,596,272.7	184,261,004.5	17,957,154.5	245,064,431.8
Өөрөө барьж байгуулсан	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-
Хасагдсан дүн	-	-	-	1,170,000.0	-	1,170,000.0
Худалдсан	-	-	-	1,170,000.0	-	1,170,000.0
Бусад	475,200,000.2	5,255,811,435.9	124,950,641.7	9,354,877,073.3	25,684,063.6	15,236,523,214.6
2023 оны 12-р сарын 31	-	1,835,330,623.6	89,079,474.7	8,186,053,682.1	394,598.0	10,110,858,378.5
Нэмэгдсэн дүн	-	286,930,011.6	6,106,255.3	471,988,029.1	1,606,352.0	766,630,548.0
Тухайн жилийн байгуулсан	-	286,930,011.6	6,106,255.3	471,988,029.1	1,606,352.0	766,630,548.0
Элэгдэл	-	-	-	1,113,398.4	-	1,113,398.4
Хасагдсан дүн	-	-	-	1,113,398.4	-	1,113,398.4
Данснаас хассан хөрөнгийн	-	-	-	-	-	-
элэгдэл	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээгээр хасагдсан	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31	-	2,122,260,635.2	95,185,730.0	8,656,928,312.9	2,000,950.0	10,876,375,628.0
Дансны үнэ C2	475,200,000.2	3,133,550,800.7	29,764,911.7	697,948,760.4	23,683,113.7	4,360,147,586.6

7.10 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь биет шинж чанаргүй ч тодорхойлж болох мөнгөн бус хөрөнгө юм. Биет бус хөрөнгө дараах шинж чанарыг агуулсан байна.

- Тусгайлан тодорхойлогдохуйц байх,
- Байгууллагын хяналтанд байх,
- Эдийн засгийн ирээдүйн үр өгөөж байгууллагад орж ирэхээр хүлээгдэж байх.

Судалгаа шинжилгээ нь шинжлэх ухаан, техникийн шинэ мэдлэг, санаа хайж олохтой холбоотой төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа тандалт юм.

Хөгжүүлэлт нь ихээхэн боловсронгуй материал, багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйл явц, систем болон үйлчилгээг бий болгох, түүнийг үйлдвэрлэл болон хэрэглээнд нэвтрүүлэх хүртлэх судалгаа шинжилгээний болон бусад мэдлэгийг хэрэглэх үйл ажиллагаа юм.

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авалт хийсэн өдөр өртгөөр нь бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн өртөг гэдэг нь тухайн хөрөнгийг худалдан авах, бий болгох үеийн бодит үнэ цэнэ буюу төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн юм.

Үлдэх өртөг гэдэг нь хөрөнгийн ашиглагдах хугацааны эцэст ашиглалтаас хасахтай холбогдон гарахаар хүлээгдэж буй зардлуудыг хассаны дараа тухайн хөрөнгөнд байж болох цэвэр мөнгөн дүн юм.

Дансны үнэ гэж санхүүгийн тайланд байгаа үлдэх өртөг буюу анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулалтыг хассаны дараах хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн дүн юм.

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг анхны өртгөөс хорогдуулалт ба үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан өнөөгийн цэвэр үнэ цэнээр санхүүгийн тайланд тусгана.

Хорогдуулалт нь хөрөнгийн хорогдуулах өртгийг ашиглалтынх нь хугацааны туршид системтэйгээр тооцсон хуваарилалт юм.

Хорогдуулах дүн нь хөрөнгийн анхны өртөг эсвэл өртөг хэмээн төлөөлүүлэн зөвшөөрсөн дүнгээс үлдэх өртгийг хассан дүн юм.

Хөрөнгийн нэр	Програм хангамж	Бусад	Бүгд
2023 оны 12-р сарын 31	7,238,819.8	1,565,893,893.0	1,573,132,712.8
Нэмэгдсэн	-	-	-
Хасагдсан	-	-	-
2024 оны 12-р сарын 31	7,238,819.8	1,565,893,893.0	1,573,132,712.8

7.10.1 Хайгуул үнэлгээний хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл-1	236,776,625.3	167,912,049.8
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл-2	158,169,499.8	158,169,499.8
Дүн	394,946,125.1	326,081,549.6

7.11 Өр төлбөр

Өр төлбөр гэдэг нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн үр өгөөжийг өөртөө агуулж байгаа нөөцөөс гарах үр дүнд хүлээгдэж буй төлбөр тооцоо болон өнгөрсөн үйл явдлаас үүссэн өнөөгийн хүлээх үүрэг юм.

Одоо байгаа өр төлбөрийг барагдуулснаар эдийн засгийн үр ашгийг агуулж байгаа нөөц буурах магадлалтай бөгөөд хэмжигдэх бүрэн боломжтой өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Өр төлбөрийг дараах аргаар хэмжиж бүртгэнэ.

- Анхны өртөг - бизнесийн хэвийн нөхцөлд өр төлбөрийг төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн
- Төлөгдөх боломжит дүн - Бизнесийн хэвийн нөхцөлд өрөө төлж барагдуулахад шаардагдаж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дискаунтчилгаагүй дүн
- Өнөөгийн үнэ цэнэ - Бизнесийн хэвийн нөхцөлд өрөө төлж барагдуулахад шаардагдаж байгаа ирээдүйн цэвэр мөнгөн зарцуулалтын дискаунтчилсан дүн.

Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээр буюу өртгөөр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнэ гэдэг нь гэрээнд заасан үнийн дүнгээс хөнгөлөлт, хасагдуулгыг хассан цэвэр дүн юм.

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор бараа, ажил үйлчилгээ, материал, сэлбэг худалдан авснаар бэлтгэн нийлүүлэгч, ажил гүйцэтгэгчдэд төлөх өр төлбөрийг дансны өглөгөөр бүртгэнэ.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх дутуу төлөгдсөн дүнг хамааруулан бүртгэдэг.

Зээл. Компанийн үйл ажиллагаанд зориулан банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг бүртгэдэг. Зээлийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож бүртгэдэг.

Өр төлбөрийг богино ба урт хугацаат гэж ангилик тайлагнана.

1. Богино хугацаат өр төлбөр
2. Урт хугацаат өр төлбөр

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх дутуу төлөгдсөн дүнг хамааруулан бүртгэдэг.

Зээл. Компанийн үйл ажиллагаанд зориулан банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг бүртгэдэг. Зээлийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож бүртгэдэг.

7.11.1 Дансны өглөг

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Дансны дотоод өглөг /байгууллагын/	100,131,985.8	51,389,774.7
Холбоотой талын өглөг	974,956,234.4	760,041,584.9
Дансны өглөг /борлуулалтын/	271,560,649.5	491,189,135.0
Бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг	1,946,128,270.8	2,965,478,942.6
Хувь хүнд өгөх өглөг	536,657,891.7	140,000,777.2
	3,829,435,032.2	4,408,100,214.5

7.11.2 Татварын өглөг

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
НӨАТ-ын өглөг	6,103,885,410.6	4,903,639,994.8
Орлогын татварын өглөг	1,285,176,061.3	963,136,738.0
ХХОАТ-ын өглөг TT-11	211,880,483.2	237,899,494.2
ХХОАТ-ын өглөг TT-12	1,903,068.8	2,354,402.2
Хойшлогдсон татварын өглөг	27,867,657.0	27,867,657.0
НДШ-ийн өглөг	180,392.6	248,503,436.3
	7,630,893,073.5	6,383,401,722.5

7.12 Урьдчилж орсон орлого

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Урьдчилж орсон орлого	471,150,000.0	157,892,000.0

7.13 Богино хугацаат зээл

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Богино хугацаат зээл	124,482,899.1	-

Ремикон ХК нь 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1950084531 тоот Санхүүгийн түрэсийн гэрээгээр Хас банкнаас авсан зээл байна.

7.14 Урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Урт хугацаат банкны зээл	2,300,000,000.0	1,595,760,000.0
Урт хугацаат зээл	3,065,512,630.1	3,216,761,515.5
Урт хугацаат хүүгийн өглөг	1,100,935,341.4	759,532,383.9
Дүн	6,466,447,971.5	5,572,053,899.3

7.15 Эздийн өмч

Компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм. Хувьцаа гэж компанийд хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийг өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас юм. Хувь нийлүүлсэн хөрөнгө гэж компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг хэлнэ. Компанийн удирдлагын эрх бүхий субъектын шийдвэрээр компанийн хувьцаат капиталыг нэмэгдүүлж болно.

Хуримтлагдсан ашиг, алдагдал. Компани үүсгэн байгуулагдснаас хойшхи хугацаанд хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэр юм. Тайлант жилийн эцэст компани, түүний салбарууд хаалтын гүйлгээ хийж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно.

Тайлант үеийн болон өмнөх жилийн хуримтлагдсан ашгийг тусдаа дансанд бүртгэнэ. Эздийн өмч бүлэгт тайлагнагдсан хөрнгүүдийн мэдээллийг тодруулбал дараах байдалтай байна.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө:

	Хувь нийлүүлэгч	тоо	Оруулсан хувь хөрөнгө
2024 оны 01-р сарын 01		1586	7,867,946,406.0
Нэмэгдсэн		-	-
Хасагдсан		-	-
2024 оны 12-р сарын 31		1586	7,867,946,406.0

Хувьцаа эзэмшигчдийг хувиар илэрхийлбэл:	Хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ	Нийт дүн	Хувь
Иргэн	78,679,464	100	7,862,547,966.0	99.9%
Байгууллага	5,398,540	100	5,398,440.0	0.1%
Дүн	78,679,464	100	7,867,946,406.0	100%

7.16 Дахин үнэлгээний нэмэгдэл

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Өмнөх дахин үнэлгээний үр дүнд бууралт үүссэн бөгөөд түүнийг тухайн хугацаанд алдагдлаар бүртгэсэн бол дараагийн дахин үнэлгээгээр бодит үнэ цэнэ өссөн тохиолдолд тухайн алдагдлын хэмжээтэй тэнцүү хэмжээний өсөлтийг нь тайлант хугацааны ашгаар хүлээн зөвшөөрч, түүнээс давсан хэсгийг дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэнэ.

Анхны дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол уг бууралтыг тайлант хугацааны алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Өмнөх дахин үнэлгээний үр дүнд өсөлт үүссэн бөгөөд дараагийн дахин үнэлгээгээр бууралт үүссэн бол өмнөх дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг тэг болтол бууруулж бичих бөгөөд түүнээс давсан дүнг тайлант хугацааны алдагдлаар бүртгэнэ.

Компанийн нь дахин үнэлгэдсэн үндсэн хөрөнгө данснаас хасагдах үед түүнд ногдох нийт дүнтэй нь өмнөх үеийн хуримтлагдсан ашигт шилжүүлэн бичнэ.

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,559,755,876.9	2,559,755,876.9

7.17 Хуримтлагдсан үр дүн

Хуримтлагдсан үр дүнгийн данс нь тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэх ба тайлант үеийн алдагдлын хэмжээгээр буурна. Хуримтлагдсан үр дүнд бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр дүн, өмнөх үеийн залруулга, дахин үнэлгээний бүрэн хэрэгжилт, дахин зохион байгуулалтын үр дүн зэрэг тохишуулах бичилтүүд хийгдэж болно.

Цэвэр хөрөнгийн бусад хэсэгт дээрх хууль тогтоомжид тусгайлан зохицуулагдаагүй эх үүсвэртэй холбоотой гүйлгээний үлдэгдлийг тусгасан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Тухайн үеийн ашиг/алдагдал	5,360,961,513.5	3,497,783,598.8
Өмнөх үеийн ашиг/алдагдал	5,012,817,022.7	1,515,033,423.9
Дүн	10,373,778,536.2	5,012,817,022.7

7.18 Орлого, зардал

Орлого нь үйл ажиллагааны орлого болон үйл ажиллагааны бусад орлого, олзыг багтаанаа. Үйл ажиллагааны орлогод гишүүдийн татвар, хураамжийн орлого, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж олсон орлого, үйл ажиллагааны бусад орлогод хүү, ногдол ашиг, эрхийн шимтгэл зарим хөрөнгийн ашиглалтын (турээсийн) орлого зэрэг хамрагдана. Зардал гэдэг нь тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор гарах цэвэр хөрөнгийн бууралт юм. Зардал нь борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардал болон бусад үйл ажиллагааны бусад зардал, гарзыг багтаанаа. Зардлыг аккруэл суурьт үндэслэн бүртгэнэ. Санхүүгийн тайлангийн жилийн өмнөх ба дараагийн үеийн үйл ажиллагаанд хамааралтай зүйлсийн төлбөр нь зардалд хамаарахгүй.

Үйл ажиллагааны бус зардалд хандив тусlamжийн зардал, торгуулийн зардал, үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн алдагдал, нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хөрөнгө, гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдлыг тус тус тусганаа.

7.18.1 Борлуулалтын орлого

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Үндсэн бүтээгдэхүүн борлуулсаны орлого	35,841,313,937.4	25,971,663,090.9
Бусад бүтээгдэхүүн борлуулсаны орлого	401,147,745.1	-
Помп ажиллуулсаны орлого	135,939,090.5	221,040,001.7
Шатахуун борлуулсаны орлого	249,037,490.9	82,936,945.5
Байр түрээслүүлсэны орлого	14,089,345.5	15,414,254.6
Худалдан борлуулах зорилготой орон сууц	2,081,818.2	4,454,338,545.5
Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт	(10,909,090.9)	-
Дүн	36,231,552,591.6	30,745,392,838.1

7.18.2 Бусад орлого

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	-	5,944,894.1
Хүүгийн орлого	1,801,979.7	944,351,7
Бусад орлого	28,833,865.4	37,336,480.1
Дүн	30,735,845.1	44,225,725.9

7.18.3 Борлуулалтын өртөг

	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
ББӨ	24,227,361,838.4	22,066,119,204.8

7.18.4 Борлуулалт маркетинг болон ерөнхий удирдлагын зардал

	2024.12.31	MNT
Борлуулалт маркетингийн зардал	Борлуулалт маркетингийн зардал	Ерөнхий удирдлагын зардал
Ажиллагчдын цалингийн зардал	3,500,000.0	2,175,892,311.7
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	-	188,577,925.0
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	8,428,740.4	91,258,786.2
Томилолтын зардал	1,163,428.4	91,919,935.6
Бичиг хэргийн зардал	1,541,304.4	24,840,443.3
Шуудан холбооны зардал	46,703,502.9	
Мэргэжлийн үйлчилгээний зардал	25,656,944.0	221,886,023.9
Сургалтын зардал	-	316,363.6
Даатгалын зардал	3,861,945.0	9,650,097.7
Ашиглалтын зардал	193,255,047.5	13,326,471.3
Засварын зардал	292,729,302.5	29,661,718.3
Элэгдэл, хорогдлын зардал	346,326,506.6	30,292,789.0
Түрээсийн зардал	18,632,000.0	13,637,272.7
Тээврийн зардал	651,300,086.4	169,568,275.1
Шатахууны зардал	399,624,380.2	89,218,438.7
Зар сурталчилгааны зардал	3,305,454.6	85,328,126.4
Хөдөлмөр хамгааллын зардал	12,588,578.5	22,023,779.9
Дүн	1,961,913,718.3	3,304,102,261.3

7.18.5 Бусад зардал

	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Санхүүгийн зардал	729,070,502.9	751,571,080.1
Хүү, торгуулийн хөнгөлөлтийн зардал	40,458,482.0	120,646,785.2
Дүн	769,528,985.8	872,217,865.3

7.18.6 Орлогын татварын зардал

	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Орлогын татварын зардал	638,242,390.3	504,890,396.0

7.19 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад байгууллагын эсрэг төрөл бурийн үүрэг хариуцлага үүсч болно. Тайлант хугацаанд болзошгүй өр төлбөр үүсч болох аливаа шинж тэмдэг ажиглагдаагүй болно.

7.20 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Ремикон” ХК-д 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах,

7.21 Аудитын илрүүлэлт

- Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан Санхүү бүртгэлийн ажилдаа ашигладаггүй нь НББ-ийн тухай хуулийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэснийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2025 онд байгууллагын үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулах

- Нийт хөрөнгийн 54.3% -ийг авлага эзэлж байгаа бөгөөд энэ авлагын 1.5% хувь нь хуулийн хэлтэст шилжиж шүүхийн шат руу шилжсэн байгаа нь үнэ цэнийн бууралтаас бий болох эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

Шийдвэрлэсэн нь: Бодит үнэ цэйин хэмжилтийг хийж үр дүнг данс бүртгэлд тусгах

- Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-ийг бараа материал дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3. Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг зориулалтын дагуу дансанд бүртгэж тайлagnah

- Тооцооны хэрэгслээр бүртгэгдэж буй борлуулах зорилготой хөрөнгийг жагсаалтаар гаргаж орлого зарлагыг тулган баталгаажуулдаггүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тайлан гаргаж баталгаажуулж ажиллах.

- Иргэн О.Эрдэнэ-Оюунтай 2024 оны 09 дүгээр сарын 18-ны Худалдах худалдан авах гэрээнд зааснаар Паблик Сивил ХХК-ийн Арцатын ам Арцат форчуун хотхоны 4-р давхар С тоот 124м.кв сууцыг 471,200,000.0 төгрөгөөр худалдах гэрээ байгуулж 21,200,000.0 төгрөгийг мөнгөөр 450,000,000.0 төгрөгийг бартераар буюу PC450-8 затварын эксковатор авахаар тохирсон байна. Бартераар авсан эксковатор нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлгүй.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг эцэслэн шийдвэрлэх.

- Эн Ти Эм ХХК тай 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 24/206-01 тоот гэрээгээр Агарта ресиденс ХХК 201 блок 3 давхар 302 тоот байрыг зуурмагийн үнэнд тооцож авсан боловч авлага өглөгөөр болон борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг эцэслэн шийдвэрлэх.

7. Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 162 дугаар тогтоол Компанийн засаглалын кодексийн бүлэг 8-т заасны дагуу дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлдэг байх. 2024 онд энэ чиглэлээр ямар нэгэн үйл ажиллагаа хийгдээгүй.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын ажилтантай болж дотоод хяналт хийж байх.

8. 2024 оны 12р сарын тайлангаар НДШ-н илүү төлөлт 180,388.03 тэй тайлагнагдсан байна. Гэтэл балансын дүнтээр 180,392.6 төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж байх талаар зөвлөмж хүргүүлж байна.

9. 2024 оны 2.25-нд авсан Татварын тодорхойлолтоор нийт татварын өр 6,340,174,537.33, илүү төлөлт 3,033,366 байна. 2024 оны татварын зардал 638,242,390.3 нэмэгдсэн. Нийт татварын өглөг балансаар 7,602,845,023.83 байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж байх талаар зөвлөмж хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аудитын байгууллагад 2025 оны 7 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны төвч утга	Нийт алдаа		Мэдээлэл тусгачтай орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		/Мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан Санхүү бүртгэлийн ажилдаа ашигладагтай.	1									1	
Нийт хөрөнгийн 54,3% -ийг авлагаа эзэлж байгаа бөгөөд энэ авлагын 1,5% хувь нь хуулийн хэлтэст шилжиж шүүхийн шат руу шилжсэн байгаа нь унэ цэнийн буураалас бий болох эрдээл байгааг илэрхийлж байна.	1	326,728.2								1	1,876,842.4
Иргэн О.Эрдэнэ-Оюунтай 2024 оны 09 дугаар сарын 18-ны Худалдах худалдан авах гэрээнд зассанар Паблик Сивил ХХК-ийн Арцатын ам Арцат форчунь хотхоны 4-р давхар С тогт 124M.кв сүүдэг 471,200,000.0 төгрөгөөр худалдах гэрээ байгуулж 21,200,000.0 төгрөгийг мөнгөөр 450,000,000.0 төгрөгийг баргераар буюу PC450-8 загварын экскаватор авахаар тохирсон байна. Баргераар авсан экскаватор нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтүй. Дотоод хянагтын тогтолцоо бүрдээгүй, 2024 онд энэ чиглэлээр ямар нэгэн үйл ажилдагаа хийгдээгүй.	1	450,000.0							1	450,000.0	
											1

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-ийг бараа материал дансанд бүртгэсэн.	1	5,341,829.2							1	5,341,829.2
Эн Ти Эм ХХК тай 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 24/206-01 тоог гарээгээр Агаарта ресиденс ХХК 201 блок 3 давхар 302 тоог байрыг зуурмагийн үнинд тооцож авсан болоч авлага өглөөвөр болон борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд бүртгээгүй.	1	196,898.4						1	196,898.4	
Тоодооны хэрэгслээр бүртгэгдэж буй борлуулах зорилготой хөрөнгийг жагсаалтаар таргаж өрдөгтэй зарлагыг тулган баталгаажуулдагтуй. Бүртгэлгүй байр, автомашин зэрэг хөрөнгийг бүртгэжкүүзж.	1	4,768,709.1						1	4,768,709.1	
2024 оны 12-р сарын тайлангаар НДШ-н илүү төлөлт 180,388.03 тэй тайлгагдсан байна. Гэтэл балансын дунгэрээр 28,048,049.64 төгрөгийн өглөгдэй гэж тайлгатгасан байна. 2024 онд НДШ-н төлөвлөгөөгт шалгait орсон бөгөөд нийт 11,323,642 төгрөгийн шимтгэл алданти ногдуулсан байна.	1	180.4						1	180.4	
2024 оны 2.25-нд авсан Татварын тодорхойлолтоор нийт татварын өр 6,340,174,537.33, илүү төлөлт 3,033,366 байна. 2024 оны татварын зардал 638,242,390.3 нэмэгдсэн. Нийт татварын өглөг балансаар 7,602,845,023.83 байна.	1	(1,265,703.9)						1	(1,265,703.9)	